

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд заасанчлан мөнхийн хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны эн тэргүүний зорилт бөгөөд 2009 онд Монгол Улс ОХУ-тай стратегийн түншлэлийн харилцааг анхлан тогтоосон юм. Улмаар 2019 онд байгуулсан “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ” нь хоёр талын харилцааг чанарын шинэ түвшинд гаргасан бөгөөд уг гэрээг хугацаагүй хэрэгжүүлэхээр баталгаажуулсан билээ. Түүнчлэн 2021 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины урилгаар Москвад айлчилж “Москвагийн Тунхаглал”-ыг баталсан нь хоёр орны олон талт харилцааг илүү идэвхтэй хэлбэрт шилжүүлэх, практик үр дүнг дээшлүүлэхэд чухал түлхэц үзүүлсэн болно.

2021 онд Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн тэгш ой тохиож, сонирхол татам үйл явдлаар дүүрэн байлаа. Түүхт ойн хүрээнд Монгол, Оросын шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтдээс хоёр улсын өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааны ололт амжилт, сорилт сургамжийг үнэлж дүгнэсэн бүтээл туурвиж, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, арга хэмжээ олныг зохион байгуулав. Тэдгээрийн дотроос Монголын Орос судлалын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын тулгамдсан зорилтуудын талаар ч оюун бодлоо шүүн уралдуулсан нь нэн ач холбогдолтой байсан юм.

Монгол Улсад Орос судлалыг шинжлэх ухаанчаар хөгжүүлэх явдал нь бидэнд туулсан түүх ба эрин үеэ танин мэдэх, ойлгож ухаарах, бодитоор үнэлж цэгнэх өргөн бололцоог олгох ач холбогдолтой болно. Монгол Улс, ОХУ-ын шинэ үеийн харилцааны түүхийн 100 жилийн ой тохиож буй энэ цаг үед тус хүрээлэнгийн Орос судлалын хөгжлийн үе шатны талаар товч тоймлон өгүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улс дахь Орос судлалын нэгээхэн голомт нь ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн дээр төвлөрөн хөгжиж ирсэн уламжлалтай. Өдгөө ч тус хүрээлэнгийн судалгааны тэргүүлэх чиглэлийн нэг нь Орос судлал байна. 1968 онд тус хүрээлэнгийн үүсэл тавигдсан үеэс Дорно дахин судлалын чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгааны ажилд тухайн үеийн ЗХУ-ын эрдэмтдийн зөвлөмж, туршлага чухал ач холбогдолтой байсны зэрэгцээ 1970-1990-ээд он хүртэлх 20 гаруй жилийн хугацаанд Оросын их, дээд сургуульд хятад, япон, солонгос, вьетнам зэрэг дорно дахины голлох орнуудын судлалаар мэргэжлийн боловсон хүчнээ төлөвлөгөөтэй бэлтгэсэн байна. Иймд Монгол Улсын гадаад орон судлал,

олон улсын харилцааны салбарын хөгжлийн эхэн үе нь ЗХУ-ын дэмжлэг, хамтын ажиллагаатай салшгүй холбоотой байсан юм.

1976 онд ШУА-ийн Дорно дахин судлалын хүрээлэн болон өргөжин байгуулагдсан үеэс тухайн үеийн БНМАУ-ын гадаад бодлого болон олон улсын байдалтай нягт уялдан капиталист биш хөгжлийн зам, гурав дахь ертөнцийн орнууд, Зөвлөлт судлал, БНХАУ-ын түүх, улс төр, эдийн засаг, соёлын өргөн хүрээтэй асуудалд голлон төвлөрч байлаа.

Өөрөөр хэлбэл, тус хүрээлэнгийн Орос судлал нь Монголын түүх судлалын салшгүй хэсэг болон хөгжсөн уламжлалтай бөгөөд Монгол, Оросын хувь заяаг хамгийн нягт холбосон ХХ зуунд Орос оронд явагдсан хувьсгалууд, социалист нийгмийн бүтээн байгуулалтын үйл явц, ЗХУКН-ын түүх, түүний үзэл суртлын баримтлалыг судлах явдал нь манай улсын Орос судлалын хандлагыг тодорхойлж, Монгол-Зөвлөлтийн харилцааны түүхийн судалгаа нь Орос судлалын нэг чухал чиглэл болон хөгжиж байв.

1990 онд Монгол оронд өрнөсөн ардчилал, өөрчлөн байгуулалтын жилүүдэд эрдэм судлалын чиг хандлагыг олон улсын жишгийн дагуу өөрчлөн зохион байгуулах, Монгол, Оросын харилцааг шинэ хандлагаар судлах шаардлага тулгарсан байна. Энэ дагуу 1991 оны 6 дугаар сарын 27-ны өдөр ШУА-ийн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэмтдийн санаачилгаар Монголын Зөвлөлт судлалын холбоо байгуулах хурал болж, холбооны дүрэм, 1991 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан Холбооны тэргүүнээр БНМАУ-ын ШУА-ийн гишүүн, ЗСБНХУ-ын ШУА-ийн гадаад гишүүн, доктор, профессор Б.Ширэндэвийг сонгосон байдаг. Тус холбоог байгуулсан зорилгынхоо тухай доктор Б.Ширэндэв ярилцлагадаа “Манай иргэдээс олон хүн Зөвлөлтөд суралцсан, ажлаар очдог, хэвлэл мэдээллийн шугамаар Зөвлөлтийн тухай өргөн мэдэж байдаг боловч Зөвлөлтийг тусгайлан судлах ажил урьд өмнө явагдаагүй” болохыг дурдаад “... Зөвлөлтөд хийгдэж буй улс төрийн өөрчлөн зохион байгуулалт, эдийн засгийн хямралаас гарахаар зохиож буй ажил зэрэг нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байдаг” тухай тэмдэглэсэн байна. Гэвч ардчилал, зах зээлийн шилжилтийн он жилүүдэд дээрх холбоо үйл ажиллагаагаа хэрхэн явуулж байсан тухай өдгөө тодорхой мэдэгдэхгүй байгаагийн зэрэгцээ 1991-1999 хүртэл тус хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалт ч мөн олонтоо өөрчлөгдөж байсны уршгаар Монголын Орос судлал дорвитой өргөжин хөгжиж чадаагүй ажээ.

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн “Шинжлэх ухааны зарим байгууллагын бүтцийн өөрчлөлтийн тухай” 138 дугаар тогтоолоор ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн сэргээн байгуулагдсанаар Монголын Орос судлал хөгжлийн шинэ үе эхэлсэн бөгөөд Орос судлалын бие даасан салбар хүрээлэнгийн бүтцэд албан ёсоор байгуулагдаж, өдгөө 23 дахь жилдээ эрдэм судлалын үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хүрээлэнгийн Орос судлалын салбар нь өнгөрсөн 23 жилийн хугацаанд ОХУ-ын гадаад бодлогын шинэчлэл, Ази, Номхон далайн бүс нутагт хандсан бодлого, Зүүн, Зүүн хойд Азийн орнуудтай тогтоосон хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграци, эдийн засгийн глобалчлалын үйл явц дахь оролцоо, ОХУ-ын Сибирь, Алс Дорнодоо хөгжүүлэх талаар боловсруулж байгаа бодлого, арга хэмжээ, Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт харилцааны бодит боломжийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү чиглэгдэж иржээ.

2021 онд тохиож буй Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулан ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс Гадаад харилцааны яамтай хамтарч “Монгол-Оросын харилцаа: Түүх, орчин үе ба хэтийн төлөв” эрдэм шинжилгээний хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр, “Олон улс судлал: Монголын Орос судлал” эрдэм шинжилгээний хурлыг 12 дугаар сарын 20-ны өдөр тус тус амжилттай зохион байгуулав.

“Олон улс судлал 2021: Монголын Орос судлал” эрдэм шинжилгээний хурал нь Монгол Улсад Орос судлалыг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлаа хэлэлцэх хүрээнд эрдэмтэн судлаачид судалгааны үнэтэй санал, дүгнэлт дэвшүүлж, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэн мэдээлэл солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсныг энд онцлон тэмдэглэе.

Мөн манай хүрээлэнгээс санаачлан зохион байгуулсан “Монгол-Оросын харилцаа: Түүх, орчин үе ба хэтийн төлөв” эрдэм шинжилгээний хуралд УИХ дахь Монгол-Оросын найрамдлын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн С.Одонтуяа, Монгол Улсын Гадаад харилцааны дэд сайд Б.Мөнхжин, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөх С.А.Краминцев, ГХЯ-ны Хөрш орнуудын газрын захирал Т.Батцэцэг, ШУА-ийн Дэд Ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатар нар оролцож, үг хэлж, илтгэл хэлэлцүүлсэнд гүнээ талархаж байгаагаа илэрхийлэе.

Дээрх эрдэм шинжилгээний хуралд оролцсон эрдэмтдийн илтгэлүүд нь ОХУ-ын улс төр, гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын стратеги, эдийн засгийн салбарын асуудлуудад голлон чиглэхийн зэрэгцээ Монгол-Оросын харилцааны түүх, худалдаа, эдийн засаг, батлан хамгаалах, шинжлэх ухаан, соёл, боловсрол, архивын салбар дахь өнөөгийн хамтын ажиллагаа, Монголын Орос судлалын хөгжлийн хандлагын талаарх өргөн хүрээтэй асуудлыг хамарчээ.

Энэхүү эмхэтгэлд Орос судлалын чиглэлээр холбогдох судалгаа хийн ажилладаг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, УАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн, Үндэсний тагнуулын Академи, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Үндэсний Төв Архив, Төв, Зүүн Европ судлалын Монголын Холбоо зэрэг эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, ТББ-ын эрдэмтэн судлаачид болон “Россотрудничество” агентлагийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газар, Улаанбаатар хот дахь Оросын шинжлэх ухаан, соёлын

төвийн удирдлагаас хэлэлцүүлсэн 15 илтгэл, түүний холбогдох хэлэлцүүлгийг сонгон авч багтаасан болно.

Энэ дашрамд онцлон тэмдэглэхэд уг эмхэтгэлд тусгасан эрдэмтдийн судалгааны санал дүгнэлт нь хувь судлаачдын байр суурь бөгөөд Монголын Орос судлалын нэгэн үеийн хөгжлийн төвшнийг илтгэн харуулахуйц илтгэлүүд багтсан болохыг онцолж байна.

Дээрх эрдэм шинжилгээний хурлуудыг танхим болон цахимаар зохион байгуулахад ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрдэмтэн судлаачид голлох үүрэгтэй оролцов. Энэ дашрамд уг эмхэтгэлийг хэвлүүлэхэд удирдлагаар хангаж ажилласан хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Д.Золбоо, эмхэтгэн хэвлүүлэх ажлыг хамтран хариуцаж ажилласан ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрхлэгч, доктор А.Нямдолжин, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Хишигжаргал нартаа болон “Бэмби сан” хэвлэлийн газрын хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

Монголын олон улс судлал бадран хөгжиж, эрдэм бүтээл ундарч байх болтугай.

*Шинжлэх Ухааны Академийн
Олон улс судлалын хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
доктор Раднаасэдийн Төрдалай*

2022 оны 5 дугаар сарын 12-ны өдөр